

## **Ажил завсардаж, орлого багассантай холбогдон үзүүлэх зээл, тусламжууд**

### **- Хувь хүнд яаралтай олгох бага дүнтэй хүүгүй зээл**

“Ковид-19” вирусын цар тахал дэгдэж хөл хорио тогтоон ажил завсарласны улмаас орлого багассан, амжиргааны дэмжлэг шаардлагатай айл өрхөд шуурхай бөгөөд түр хугацааны тусгай хүүгүй зээлийг олгож байна.

Лавлах утас: 025-280-5176 (Эрүүл мэнд, халамжийн хэлтэс, эсвэл оршин суугаа газрын харьяа хот, дүүргийн захиргааны Эрүүл мэнд, халамжийн хэлтэст хандана уу.)

### **- Ажилгүй болсон иргэдийн амьжиргааны зээл <гадаад холбоос>**

Компани дампуурсан эсвэл халагдсаны улмаас ажилгүй болсон иргэдэд амьжиргааны зээл олгож байна.

Лавлах утас: 025-280-5260 (Ажил эрхлэлтийг дэмжих хэлтэс, эсвэл оршин суугаа газрын харьяа хот, дүүргийн Нийгата мужийн Хөдөлмөрийн банкны салбарт хандана уу.)

### **- Ажилчдын амьжиргааг дэмжих тусгай зээлийн систем <гадаад холбоос>**

“Ковид-19” вирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан орлого эрс буурсан ажилчидад амьжиргааны зээл олгоно.

Лавлах утас: 025-280-5260 (Ажил эрхлэлтийг дэмжих хэлтэс, эсвэл оршин суугаа газрын харьяа хот, дүүргийн Нийгата мужийн Хөдөлмөрийн банкны салбарт хандана уу.)

### **- Байрны төлбөрийн тусламж**

Бизнес хаагдсан, ажилгүй болсон хоёр жилийн дотор эсвэл орлого эрс буурсан ажилгүйтэй ижил нөхцөлд байгаа хүмүүст тодорхой хугацаанд орон сууцны түрээсийн төлбөрийг төлөх тусламж.

Лавлах утас: 025-280-5176 (Эрүүл мэнд, халамжийн хэлтэс, эсвэл оршин суугаа газрын харьяа хот, дүүргийн захиргаанд хандана уу.)

### **- Оюутнуудад их, дээд сургуулийн төлбөрийн тусламж**

Өрхийн орлого бага буюу татвараас чөлөөлөгдсөн өрхийн болон цар тахлын улмаас орлого эрс буурсан өрхийн оюутнуудад сургалтын төлбөр, элсэлтийн хураамжийг хөнгөлөх, их дээд сургуулийн төлбөрийн зээл болон тэтгэмжийг олгож байна.

Холбогдох байгууллагууд:

Тухайн их, дээд сургуулийн Оюутны хэрэг хариуцсан хэлтэс,

Японы Оюутныг дэмжих байгууллагын Тэтгэмжийн асуудал лавлах утас: 0570-666-301,

Нийгата мужийн Их, дээд сургуулийн хөгжлийн хэлтэс: 025-280-5267

- **Хүүхдийн асрамжийн газраас бие дааж гарсан хүмүүст үзүүлэх тусламж**

“Ковид-19” вирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан ажил олдохгүй байгаа эсвэл ажиллах боломжгүй байгаа нас бие гүйцсэний улмаас асрамжийн газрыг бие дааж гарсан хүмүүст байрны түрээсийн төлбөрийн зээлийг олгоно.

Лавлах утас: 025-280-5216 (Хүүхэд, гэрбүлийн хэлтэс, эсвэл оршин суугаа газрын харьяа хот, дүүргийн захиргаанд хандана уу.)

**Татварын дэмжлэг**

- **Татварын хөнгөлөлт**

“Ковид-19” вирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан татвар төлөх боломжгүй болсон иргэдэд татварын барьцаагүй, сунгалтын төлбөргүйгээр татвар төлөх хугацааг 1 жилээр хойшлуулах хөнгөлөлт.

Лавлах:

- Улсын: Канто Шин Эцү татварын албаны Татвар хөнгөлөлтийн лавлах 048-615-3007

- Мужийн: Нийгата Татварын хэлтэс 025-280-5048

- Мужийн бусад орон нутгийн татварын албаны хэлтсүүдэд хандана уу.

**Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө**

- **Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө өгөх төвүүд**

“Ковид-19” вирусын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон иргэдэд мужийн дараахи 3 төвд зөвлөгөө өгч байна.

- Нийгата Хөдөлмөрийн зөвлөлдөх төв, утас: 0250-23-6110

- Нагаока Хөдөлмөрийн зөвлөлдөх төв, утас: 0258-37-6110

- Жёоэцү Хөдөлмөрийн зөвлөлдөх төв, утас: 025-526-6110